

ОЛОН УЛСЫН СТАТИСТИК ҮҮСЧ ХӨГЖСӨН ҮНДСЭН ҮЕ ШАТУУД, ГЛОБАЛ СТАТИСТИК СИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

*МУИС, ОУХС-ийн дэд профессор,
доктор (Ph.D) Д.Тунгалаг*

1. Олон улсын статистик үүсч хөгжсөн үндсэн үе шатууд

Статистик үүсч хөгжих үндсэн нөхцөл нь XVI зууны үеэс эхлэн Баруун Европын орнуудын засгийн газар өөрсдийнхөө иргэдийн тухай мэдээлэл (хүн амын тооллого)-ийг олж авахаас үүсэлтэй гэж үздэг.

Мэдээллийг боловсруулах статистикийн аргуудыг анх хэрэглэсэн, тэр үеийн нэрт математикчуудтай хамтарч статистикийн судалгаа явуулахын чухлыг ухуулж анх Статистикийн төв комиссыг байгуулж байсан Бельгийн эрдэмтэн **Адольф Кетле** (1796-1874)-г орчин үеийн олон улсын статистикийн эцэг гэж нэрлэдэг. Гэхдээ Кетле нь математикч байсан учраас түүний судалгаанд хэрэглэгдэж байсан аргууд нь математикийн зарчим дээр суурилсан байсан. Энэ байдал нь мөн тиймэрхүү маягийн тусгай байгууллагууд бий болж байсан бусад улсуудад статистикийг хөгжүүлэхэд нөлөөлсөн ба одоо хүртэл математикийн чухал хэсэг болж явдаг олон улсын статистикийн шинж чанарт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсээр ирсэн байна.

Өнөөдөр статистикийн ерөнхий онол олон улсын практикт Statistical Abstract гэж нэрлэгдэхээс гадна математик статистикийн онолын хэсэг болж, харин нийгэм-эдийн засгийн статистик (зарим улсуудад аж ахуйн статистик гэж нэрлэгддэг) нь салбарын шинжлэх ухааны системд багтдаг болов. Харин математик статистик бол математикийн нэг хэсэг нь болдог.

XX зууны эхэн хүртэл гадаадын орнуудад статистикийн байгууллагуудыг зохион байгуулах нэгдсэн, зохицсон систем байгаагүй. Бүр XVII зууны үеэс эхлэн өөрийнхөө үйлчлүүлэгчдийн даатгалыг тодорхойлохын тулд нас баралтын статистик хүснэгтийг ашиглаж ирсэн даатгалын байгууллагуудад л статистик тодорхой хэмжээгээр хөгжиж иржээ.

Улсын болон хувийн төрөл бүрийн байгууллагууд эдийн засаг, засаг захиргаа, газар нутаг, хүн ам, худалдааны шинж чанартай мэдээллүүдийг авах зорилгоор тодорхой хэмжээний статистик судалгаануудыг явуулж байжээ. Статистикийн практикийн иймэрхүү зохион байгуулалтыг яагаад ч зохицуулж болохгүй байсан. Статистикийн судлах зүйл, үзүүлэлт, мэдээлэл цуглуулах, боловсруулах арга зүйн талаар тогтсон дүрэм байгаагүй. Иймээс ажлын өртгийн талаасаа ч, хэрэгтэй мэдээллийг олж авах энгийн чанар, хурдаасаа ч тухайн үедээ л зохистойд тооцогдох статистикийн аргуудыг ашиглаж байжээ.

Статистикийн боловсруулалтын иймэрхүү системгүй байдлын уршгаар авсан мэдээллээ суурь болон өнгөрсөн үетэй болон бусад статистик үзүүлэлтүүдтэй харьцуулах боломжгүй байсан.

Олон улсын статистикийн салбарт олсон амжилт нь тодорхой эрдэмтдийн үйл ажиллагааны үр дүнтэй салшгүй холбоотой. Энд хууль тогтоогчид, улс төрчид, газрын эзэд нь өөрийнхөө үйл ажиллагаанд статистик судалгааг ашиглах хэрэгтэй гэдгийг баталсан Их Британий эмнэлгийн албаны нэрт өөрчлөн байгуулагч **Флоренс Найтингейл** (1820-1910)-ийг дурьдахгүй өнгөрч болохгүй.

Статистикийн хөгжилд „Пирсоны хэмжүүр“-ээрээ бидний танил болсон Английн эрдэмтэн Карл Пирсон (1857-1936) нэлээд үнэтэй хувь нэмэр оруулсан гэж үздэг. Мөн корреляцын статистикийг боловсруулахад гавьяа байгуулсан английн сэр **Фрэнсис Гальтон** (1822-1911)-ыг нэрлэх хэрэгтэй. Нэлээд сүүлд **Рональд Фишер** (1890-1962) статистикийн салбарт маш чухал алхам хийсэн.

XX зууны эхээр АНУ болон Баруун Европын улсуудад Засгийн газрын статистикийн байгууллагууд бий болж эхэлсэн. Тэдгээр нь үндсэндээ „ценз“ гэж нэрлэгддэг хүн амын тооллого явуулах, мөн хэвлэхэд зориулагдсан боловсруулалтын материалыг бэлдэх ажлыг гүйцэтгэж байв.

Эдийн засгийн үйл ажиллагаанд төрийн оролцоо өргөжихийн хэрээр статистик судалгааны хэрэгцээ өсдөг. Хэтийн төлөв, программчлалын үндсэн дээр аж ахуйн субъектүүдийн үйл ажиллагааны статистик тодорхойлолтуудыг төрөөс зохицуулах болсон ба шинээр бий болж байсан монополистуудад худалдааны зах зээлийн хэмжээг үнэлэх, үйлдвэрлэлийн ашиг тооцох гэх мэт зайлшгүй хэрэгцээ гарч ирсэн. Статистик аргуудыг ашигласны үр дүнд бий болсон үнэ цэнэ мэргэжилтнүүдийн өмнө статистикийн мэдлэг, судалгааны аргуудын ядаж үндсийг нь мэдэж байх зайлшгүй шаардлага тавьсан гэж хэлж болно. Иймээс олон улсуудын сургалтын байгууллагуудад статистикийг зайлшгүй судлах шаардлага тулгарч байсан.

Дэлхийн янз бүрийн орнуудад олон тооны улсын болон хувийн байгууллагууд статистикийн ажил хашиж байна. Жишээ нь, АНУ-д улсын статистикийн байгууллагууд: Худалдааны яамны Нийгэм-эдийн засгийн газар харьяалагддаг Цензийн товчоо, Эдийн засгийн судалгааны товчоо, Хөдөлмөрийн яамны дэргэдэх Хөдөлмөрийн статистикийн товчоо г.м. Түүнээс гадна Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааны алба, Хүн амын ердийн хөдөлгөөний статистикийн үндэсний товчоо зэрэг байгууллагууд статистикийн судалгааны ажлыг явуулж байна.

Баруун Германд статистик боловсруулалтыг Дотоод явдлын яамны Холбооны статистикийн газар хийж байна.

Францын Санхүү, эдийн засгийн яамны Статистик, эдийн засгийн судалгааны үндэсний институт улсын хэмжээний бүх статистик судалгааны ажлыг зохицуулж байгаа ба зарим орнуудад Статистикийн төв газрууд статистикийн ажлыг толгойлж байна.

Засгийн газрын дэргэдэх Статистикийн улсын байгууллагуудаас гадна барууны орнуудын практикт хувийн секторын захиалгад, мөн

тодорхой хэмжээгээр улсын сонирхолд нийцсэн хувийн статистикийн албаны систем бий болсон байна.

Барууны орнуудын хувьд статистик судалгааны нэгдсэн аргачлал байхгүй байсан нь тухайн үедээ нэлээд анхаарал татсан асуудал болж байв. Статистик үзүүлэлтүүдийн тооцоог янз бүрийн аргаар хийснээр тэдгээрийг хооронд нь харьцуулах боломжгүй болгож байсан. Улс орнуудад хөдөө аж ахуйн хүн ам (өөрөөр хэлбэл хөдөө аж ахуйд ажиллаж байгаа хүний тоо)-ын тоог харьцуулах анхны оролдлогоос л энэ асуудлын чухал нь харагдаж байсан.

Эрдэмтэд дараахи асуудалтай тулгарч байсны жишээ нь фермүүдэд ажиллаж байгаа ажиллагсдын тоог тодорхойлохын тулд АНУ-ын Хөдөө аж ахуйн яам судалгааны нэгж болгож фермийг авч байхад Хүн амын тооллогын улсын товчоо өрхийг авах жишээтэй. Зарим улсуудад хөдөө аж ахуйн ажиллагсдын тоонд ажиллаж байгаа бүх хүүхдийг оруулдаг бол зарим оронд зөвхөн 14 наснаас дээш насны хүүхдийг оруулдаг. Энэ байдлаас гарах зайлшгүй шаардлага тулгарсан. Гэвч янз бүрийн үндэсний статистикийн зарчмууд, аргачлалуудыг зохицуулах оролдлого нь олон улсын хэмжээнд тохирсон санхүү, эдийн засгийн суурь, түлхэц байхгүйгээс болж зогсонги байдалд байсан боловч энэ байдлаас гарахын тулд статистик судалгааны нэгдсэн аргачлалыг бий болгох зайлшгүй шаардлага гарч ирсэн байна.

2. Глобал статистик системийн өнөөгийн байдал

Улс хоорондын уялдаа холбоо өргөжиж, нэгдсэн капиталист аж ахуйн систем бий болсноор дэлхийн статистикийн зураг төрхийг тодорхойлох зайлшгүй хэрэгцээ, боломж гарч ирж байна. Янз бүрийн орнуудын статистик судалгааг нэг аргачлалаар хийгдсэн, өөрөөр хэлбэл нийцүүлсэн тохиолдолд л зэрэгцүүлэх бололцоотой нь ойлгомжтой юм.

Нийцүүлэх ажил хийсэн анхны байгууллага нь **Олон улсын статистикийн конгресс** юм. 1919 оноос эхлэн Үндэсний лигт олон улсын статистикийг бий болгоход чиглэгдсэн тогтмол арга хэмжээнүүд явагдаж эхэлсэн ба түүний нэлээд том ололт нь олон улсын статистик судалгааны нэгдсэн аргачлалын үндсийг баталсан явдал юм.

1946 оноос эхлэн НҮБ-ын дэргэд **НҮБ-ын Статистикийн комисс** ажиллаж байна. Тэрээр тогтмол чуулган явуулах хэлбэрээр ажилладаг.

Статистикийн комиссын дэргэд эдийн засгийн статистик, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд тохирсон тусгай зорилготой 6 дэд бүлгээс бүрдсэн тусгай ажлын бүлэг байгуулагдан ажиллаж байна. Үүнд:

1. үндэсний тооцоо
2. аж үйлдвэрийн статистик
3. олон улсын худалдааны статистик
4. санхүүгийн статистик
5. үнийн статистик
6. хүрээлэн байгаа орчны статистик

Дээрх дэд бүлгүүд мэдээлэл цуглуулах, аргачлал боловсруулах, дэлгэрүүлэх, боловсон хүчин бэлдэх, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэдэг.

Түүнээс гадна НҮБ-ын нарийн бичгийн газрын бие дааж үйл ажиллагаагаа явуулдаг дэд бүлэг, мөн Статистикийн комиссын ажлын бүлэг болох **НҮБ-ын нарийн бичгийн газрын статистикийн хэлтэс** ажилладаг.

Статистикийн хэлтсийн үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Статистикийн комиссын чуулганд материал бэлдэж оруулах;
- статистикийн тоо материалыг цуглуулах, боловсруулах (үнэн зөв мэдээлэл), хэвлэх;
- бие даасан үнэлгээг явуулах;
- улсуудад практик тусламж үзүүлэх;
- мэргэжилтнүүдийн албан томилолтыг хариуцах.

НҮБ-ын статистикийн хэлтэс өөрийнхөө үйл ажиллагааны хагас зуун жилийн түүхэнд олон улсын статистикийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан. Янз бүрийн улсуудын, бүсийн статистикийн комиссуудын боловсруулсан НҮБ-ын статистикийн системд багтдаг статистикийн тоо материалуудыг хэвлэсэн товхимлууд онцгой ач холбогдолтой юм. Үүнд:

- Хүн амын статистикийн эмхтгэл (*Demographic Yearbook*) НҮБ-ын статистикийн комиссын Швейцарийн салбарт хийгддэг. Түүний төв нь Женевт байрладаг. Энэ товхимлоос дэлхийн улсуудын хүн амын тоо, төрөлт, нас баралт, хот, хөдөөгийн хуваарилалтыг харж болно.

- Дэлхийн улсуудын хөдөлмөрийн нөөцийн статистик нь **Олон улсын хөдөлмөрийн байгууллага** (*International Labour Organization*)-ын ивээл дор явагддаг. Түүний төв нь Женевт байрладаг. Энэ байгууллагын хэвлэл: Хөдөлмөрийн статистикийн эмхтгэл (*Yearbook of Labour Statistics*), Цалин, ажлын цаг, хүнсний бүтээгдэхүүний үнийн статистик (*Statistics on occupational wages and hours of work and food prices*), хөдөлмөрийн талаархи тогтмол бюллетенүүд (*Supplement of the bulletin of Labour Statistics u Current international recommendations on Labour Statistics*).

- **ФАО - Хүнс, хөдөө аж ахуйн комиссын** статистикийн эмхтгэл нь ургац хураалт, үр тарианы талбай, хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ, чанарын түвшин, ялангуяа хүнсний бүтээгдэхүүн, түүний калорийн хэмжээг харуулсан мэдээг агуулдаг. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн комиссын төв нь Италийн Римд байрладаг.

- **ЮНЕСКО**-гийн статистикийн эмхтгэлд олон улсын хэмжээнд бичиг үсгийн боловсролын түвшин, соёл, шинжлэх ухааны хөгжлийг харуулсан тоо мэдээлэл ордог.

Жил бүрийн эдгээр эмхтгэлүүд нь урьдчилан цуглуулж авсан тоо материал дээр хийгддэг сар бүрийн статистик бюллетений үндсэн дээр суурилдаг юм. Дээрх статистикийн үндсэн эмхтгэлүүдээс гадна дөчөөд жил гарч байгаа дэлхийн худалдаа, санхүү, аж үйлдвэрийн гэх мэт эмхтгэлүүд байдаг. Тэдгээрийг бэлдэхэд НҮБ-ын бүсийн статистик дэд

бүлгүүдээс гадна тэдний шийдвэрээс бүрэн хэмжээгээр үл хамаардаг тусгай байгууллагууд оролцдог. Энэ нь **Дэлхийн банк** (*World Bank*)-ны статистикийн товхимол юм. Урьд нь түүнийг Сэргээн босголтын ба хөгжлийн олон улсын банк (*International Bank for Reconstruction and Development*) гэж нэрлэдэг байсан ба Дэлхийн банкны гишүүн орнуудын эдийн засгийн хөгжилд туслалцаа үзүүлэх үүрэгтэй байгууллага байсан.

Олон улсын статистикийн нэлээд чухал товхимлын тоонд дэлхийн улсуудын эдийн засгийн байдлыг харуулдаг **Олон улсын валютын сан** (*International Monetary Fund*)-ын товхимол зүй ёсоор ордог. Энэ нь статистикийн жил бүрийн эмхтгэл (*International Financial Statistics*), Нью-Йоркод хэвлэгддэг сар бүрийн тогтмол бюллетень (*Bulletin of IMF*) юм.

Дээр дурьдсан статистик судалгаанууд нь англи, франц, герман, испани хэлээр хэвлэгддэг, **албан ёсны мэдээлэл** гэсэн статустай товхимлууд юм. Энэ нь мэдээллийн үнэн зөв байдал, хариуцлагаараа өндөр түвшинд хийгдэх шаардлагатай НҮБ-ын албан ёсны илтгэл, диссертаци, мэдээллүүдэд ашиглаж болох найдвартай, шалгагдсан материалууд гэсэн ойлголт юм.

Статистикийн мэдээллийн салбар дахь өрсөлдөөн өргөжиж байгаа зах зээлийн харилцааны нөхцөлд албан ёсны статистикийн зэрэгцээ *албан ёсны биш мэдээлэл* бас байдаг. Үүнд янз бүрийн улсуудын нийгэм, эдийн засгийн амьдралын тухай өөрийн судалгааны үр дүнг нийтэлсэн хувийн статистикийн фирм, байгууллагын бүтээлүүдийг нэрлэж болно. Жишээ нь, АНУ (Лос-Анжелес)-д хэвлэгддэг олон улсын статистикийн эмхтгэл *Statistical Abstract* юм. Хэдийгээр мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгддэг, гаднах төрхөөрөө гайхалтай, практик ач холбогдолтой, албан хэрэгч хийгддэг *Statistical Abstract*-ын мэдээлэл нь албан ёсны хувьд хязгаарлагдмал ач холбогдолтой байдаг.

Ерөнхийдөө олон улсын статистикийн концепцийг дараахи байдлаар тодорхойлж болно. НҮБ-ын дэргэдэх Статистикийн комисс нь энэ концепцид голлох үүрэг гүйцэтгэдэг. Дэлхийн 150 гаруй улс өөрийнхөө статистикийн мэдээллийг өгдөг. Статистикийн комисс нь дэлхийн байгууллага учраас социалист системийн үед ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын мэдээллийг цуглуулж эмхтгэдэг байсан. Иймээс олон улсын статистикийн хоёр түвшин бий болжээ гэж үздэг. Нэгдүгээрт, НҮБ-ын нэгдсэн аргачлал дээр үндэслэгдсэн олон улсын статистик, хоёрдугаарт, олон улсын үндэсний статистикийн практик гэж хувааж болох юм. НҮБ-ын дэргэдэх Статистикийн комисс нь үндэсний статистикийн стандартыг зэрэгцүүлэх үзүүлэлтэд шилжүүлэх бодлогыг биелүүлдэг байна.

Оросын өөрчлөн байгуулалтын үед статистикийн мэдээллийг хэрэглэгчид нь олон улсын статистикийн стандартыг үндэсний статистикийн мэдээллийн албанд зайлшгүй нэвтрүүлэх шаардлагатайг ойлгож түүнийг хэрэгжүүлэх явцад статистикийн судалгааны дээрх дэд бүлгүүд Дэлхийн (глобал) статистикийн систем (ГСС) гэсэн нэртэй олон улсын тусгай статистикийн бүтэц болон нэгдсэн ба энэ бүтцэд ГСС-ийг

байгуулахад оролцсон улсуудын үндэсний статистикийн газрууд нэгдэж орсон байна.

НҮБ-ын дэргэдэх Статистикийн комисс нь олон улсын статистикийн стандарт ангилал хийхэд голлох үүрэг гүйцэтгэдэг. Тэрээр янз бүрийн улсуудад статистикийн стандартыг тухай бүр нэвтрүүлэхэд хариуцлага хүлээхээс гадна тэдний статистикийн практикт дэлхийн стандарт аргачлалыг хэрэглэхэд хяналт тавих үүрэгтэй.

Статистикийн аргачлалыг нийцрүүлэх үндэс нь сайн дурын зарчим дээр үндэслэгдэх бөгөөд НҮБ-ын аргачлал дээр хийгдсэн олон улсын статистикийн стандартын систем нь саналын шинж чанартай. Ингэснээр статистикийн үзүүлэлтүүдийг тооцох аргыг зөв сонгохоос гадна өөрийнхөө практикт үндэсний болон олон улсын стандартад тохирсон аргуудыг ашиглах бололцоотой. Гэхдээ НҮБ-ын болон Дэлхийн банкны өөрийнх нь товхимлын статистик хамгаалалтыг бий болгоход статистик судалгааны өөрийн зарчим, аргуудыг хатуу баримтлах шаардлагатай. НҮБ-ын аргачлал зарим талаараа Дэлхийн банкны аргачлалаас ялгаатай гэдгийг хэлэх нь зүйтэй.

Дэлхийн статистикийн системд:

1. НҮБ-ын дэргэдэх Статистикийн комисс;
2. НҮБ-ын салбарын статистикийн дэд бүлгүүд;
3. НҮБ-ын болон олон улсын байгууллагуудын статистикийн товхимлын систем;

4. НҮБ-ын мэргэжлийн байгууллагууд:

(ФАО - НҮБ-ын хүнс, хөдөө аж ахуйн комисс, ЮНЕСКО - НҮБ-ын Шинжлэх ухаан, соёл, боловсролын хамтын ажиллагааны комисс, ВОЗ - Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, ВБ - Дэлхийн банк, МВФ - Олон улсын валютын сан, ВТО - Дэлхийн худалдааны байгууллага);

5. Улс хоорондын байгууллагуудын статистикийн албууд:

ОЭСР - (Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага), ЕС - (Европын холбоо), СНГ - (Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг);

6. Бүсийн статистикийн байгууллагууд:

(ЕВРОСТАТ - Зах зээлийн орнуудын статистикийн байгууллага, СНГ -ийн орнуудын статистикийн улсын хороо);

7. Дэлхийн эдийн засагт эзлэх үүрэг ролийг тодорхойлохын тулд улс бүрийн боловсруулсан олон улсын статистикийн (жишээ нь Оросод „Орос ба дэлхийн улсууд“ гэсэн нэртэй статистикийн эмхтгэл байдаг) эмхтгэлүүд ордог.

Эдгээр статистикийн төвүүдийн хооронд хатуу харьяалал байдаггүй. Харин зохицуулах үүрэг гүйцэтгэдэг НҮБ-ын Статистикийн комисс нь „нэгдүгээр зэргийн“ албан ёсны статустай байгууллага юм. НҮБ-ын Статистикийн комисс нь олон улсын стандарт ангиллын ерөнхий жагсаалтыг гаргахаас гадна олон улсуудад хэрэгжүүлэх хариуцлагыг хүлээдэг.

Дэлхийн статистикийн системийг бий болгох үндсэн зорилгоор үндэсний болон олон улсын түвшинд статистикийн үйл ажиллагаа

явуулахад байгаа нөөц бололцоогоо үр ашигтай ашиглах бодлого чухлаар тавигдаж байна.

Ашигласан ном

1. Сиденко А.В., Башкатов Б.И., Матвеева В.М. Международная статистика. - М.: 1999.
2. Сиденко А.В., Матвеева В.М. Международная статистика. - М.: 2000.
3. Статистический словарь. – М.: 1996.
4. Товарная номенклатура внешнеэкономической деятельности Содружества Независимых Государств. – М.: 1996.
5. Тайна традиционной статистики Запада. – М.: 1998.

The article describes evolution , development stages of international statistics, present day system of global statistics as well as organizations comprising the system and provides information sources of international statistics.